

АМАРСАНААГИЙН
БОСЛОГО БА МАНЖИЙН ТӨР

Ц. ЖАМБАЛДОРЖ

Товч агуулга: Гурван сарын хугацаанд Зүүнгарыг эзэлсэн Чингийн төр, ойрадууд цэргийн цааз зөрчих, жанжин сайдуудын зөвшөөрөлгүй бусдыг дур мэдэн хороох, эд зүйлийг дээрэмдэх зэрэг хэрэг гарч байсан ч ойрадуудын итгэлийг алдахаас болгоомжилж, тодорхой арга хэмжээ авалгүй өнгөрөөж байв. Өөрөөр хэлбэл, хэдий Зүүнгарыг эзэлсэн авч чуулган, хошуу хэмээх Манжийн засаг захиргааны тогтолцоог хэрэгжүүлэх хүртэл ойрадуудын байр байдлыг харзнаж байв. Чухам тийм учраас Илд давшсан цагаас халхад бүхий гэр бүл, албатыг Зүүнгарт нүүлгэхээр бэлтгэж, Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигийг зөрчиж, албаны морьт тэмээ, цэргийн хэрэглэлийг эс буцааж, хойдын 1500 цэргийг тараалгүй тус хэрэгт дайчилахаар төлөвлөж байсан Амарсанааг Илд цаазаар авбаас ойрадууд бослого үймээн гаргаж болзошгүй тул түүнийг Халуунаас зайлах ордонд дуудах болсон юм. Харин Амарсанаагийн бослого гарснаар Чингийн төрөөс ойрадуудыг хядах, бусдаас салгаж нүүлгэх болсноор Зүүнгарын талаарх анхны бодлого өөрчлөгдөв.

Түлхүүр үг: *Зүүнгарын мөхөл, Амарсанаагийн бослого, Далай лам, Лхас, Ил*

Удиртгал

Амарсанаагийн бослогын тухай судалгаанд, зайлшгүй хөндөгдөх асуудал бол тус бослогын хариуд Манжийн төрөөс авсан арга хэмжээ болно. Энэ талаар манай түүх бичлэгт, Амарсанаа Халх дахь хойд, хошууд нар манж нарт баригдсаныг сонсоод Тэнгэрийн тэтгэсэн хаанд бараалхах зам зуураас зугтсан¹, буучины бүгдийн дарга Агзул манжийн “500 түшмэл цэрэг”-ийг хядан устгаад Амарсанаатай нийлэхээр одох гэж байсанд, ван Базаршидийн хамт буцаж явсан

¹ Буянчуулган, Б. Дөрвөн Өөлдийн түүх, Б.Түвшинтөгс, Д.Баярсайхан (хөр). // *Bibliotheca Oiratca*. Том.Х. Улаанбаатар, 2008, 125.

500 сахар, солон цэрэг очиж хядсан², Зүүнгарыг дайлсан “50000 цэрэг”-ээс “20000” орчим нь бослогын цэрэгт хядагдсан тул Манжийн төрөөс Амарсанаагийн бослогыг дарахаар “30000” цэрэг татаж илгээсэн³ гэх мэтээр өгүүлсэн буй.

Харин манай Үндэсний Төв Архив (хойшид ҮТА хэмээн товчилно)-т хадгалагдаж буй М180 буюу Амарсанаагийн бослогын тухай баримтын мэдээнээс үзвэл, 1755 оны 8 сарын 19-нд Амарсанаа Халуунаас зайлах ордонд очих зам зуураас зугтахад, түүнийг нэхсэн Лимпилдорж, Юндэ нарт баригдсан ойрадууд, Амарсанаа халхад бүхий хойд, хошууд нарыг Зүүнгарт нүүлгэхээр удаа дараа элч илгээсэн, буучин отог Амарсанаагийн гэр бүлийг Алтайд угтах, хадаан, авгас отгууд Эрээн хавиргын их мянганы тайж Баяр, зайсан Хасагшар нарыг довтлох төлөвлөгөөг мэдэгдэв.⁴ Тиймээс Чингийн төрөөс дээрх мэдээллийг олж авсан даруй шаардлагатай арга хэмжээг авч эхэлжээ. Үүнд, 1755 оны 8 сард халхад бүхий хойд, хошууд нарыг хураан авч, буучин отгийг хядсан билээ.

Дээрх мэт өмнөх түүх бичлэг хийгээд архивын баримтын мэдээ зөрөх тул, тус өгүүлэлд, Монгол улсын архивын баримтыг 2012 онд Бүгд Найрамдах Хятад Ард улсын Түүхийн Нэгдүгээр Архив (цаашид БНХАУ-ын ТНА гэж товчилно)-аас эмхэтгэн гаргасан *Чингийн үеийн Шинжаанд холбогдох манж хэлээрх архивын данс*, 283 боть баримтын эмхэтгэл болон *Зүүнгарын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг*-ийн мэдээтэй хамтатгаж, Амарсанаагийн бослогыг дарахаар Манжийн төрөөс 1755 оны 8 сараас тус оны эцэс хүртэл хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагааг авч үзье.

1. Халх дахь Амарсанаагийн гэр бүл, албат

Манж Чин улс 1755 оны 6 сар гэхэд төлөвлөгөө ёсоор Зүүнгарыг эрхшээлдээ оруулж, сан хүүг харгалзах, өртөө харуул залгамжлуулах зэрэгт хүрэлцэх цэрэг үлдээж⁵, 1755 оны 7 сарын дундуур хоёр замын цэргээ буцаан татсаны дараахан Амарсанаагийн зааврын дагуу авгас, хадаан, хэрээд, урууд, цоохор, хурман отгууд бослого гаргаж, Манас гол, Логлуны хавийн 20 орчим өртөөг довтолж, Ил

² Ишжамц, Н. *Монголын ард түмний 1755-1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл (Амарсанаа, Чингүнжав нарын бослого)*, Улаанбаатар, 1962, 32-33.

³ Мөн гэнд, 33.

⁴ МУҮТА, М-180. Д-1. Хн-34. Б-1.

⁵ Тухайлбал, умард замд илгээсэн нийслэл хот [Бээжин]-ын манж, солон цэргээс Бархөл, Улиастайд тус бүр 500 цэрэг үлдээж Пүкин, Даш нарт хариуцуулж суулгасан байна. *Чингийн үеийн Шинжаанд холбогдох манж хэлээрх архивын данс* (清代新疆满文档案汇编, Qīng dài xīnjiāng mǎn wén dǎng'ān huìbiān), Боть 12. 广西师范大学出版社. 2012. ТТ20 он (1755)-ы 9 сарын шинийн 6-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 392-394.

дэх цэргийн хүрээний холбоо харилцааг таслав.⁶ Энэ тухай, Үрүмчид суух өрнө дахиныг тогтоох жанжин Юнчанд, тус оны 8 сарын 20-нд хиа Мачан, Үрүмчийн өртөөг захирах бичээч Дасанга нараас Манас голын цаад гурван өртөөг зуу гаруй ойрад довтолсон тухай мэдүүлсэн тул жанжин Юнчан, өрнө замын өртөөг захирах цахарын бүгдийн дарга Аминдоо, монгол хэл мэдэх мянгат Цэвдэн, Иншан нарыг цэрэг авч, тайж Занагарав, Намхи, Худалиг нартай холбоо тогтоож, тасарсан өртөөг залгамжлахыг тушаахын сацуу туслан захирах дарга Карнад цэргийн хүрээнд бүхий солон, барга 30, хотон, ногоон тугийн 70 цэргийг өгч Ил дэх мэдээг сурвалжлуулахаар 8 сарын 21-нд илгээсэн байна.⁷

Мөн энэ үед, Хүрээнээс Богдын шавийг харгалзах хошууг захирах занги Дахаа, Амарсанаагийн Жавзандамба хутагтад илгээсэн Төгс, Мөнх нарыг барьж⁸, Улиастайд хүргүүлсэнд, тэд Амарсанаа бослого гаргаж, өрнө замын өртөө, Ил дэх цэргийн хүрээг довтолж тухай мэдүүлсэн тул, Улиастайд суух хуувийн сайд Арантай, Зүүнгарт нэвтрэх уулын замыг мэдэх захчины дэмч Даваа, Турфаны бэг Мангалиг нарыг Банди, Оёнгү, Саарал нарын мэдээг авуулахаар илгээсэн боловч хүрч чадаагүй ажээ.⁹

Чингэж, манжийн жанжин сайдууд юуны өмнө Ил дэх манжийн цэргийн хүрээтэй холбоо тогтоох, үүний тулд тасарсан өртөөг аль болох хурдан залгамжлуулах арга хэмжээ авахын сацуу, хойдын бэйл Чимхүүр, Пүрэв, бэйс Дэжид, Хишиг, тайж Олчун нар халх дахь Амарсанаагийн албатууд оргох тухай мэдэгдсэн тул¹⁰, Улиастайн цэргийн хүрээнд сууж буй мэйрэний занги Пүкинд, Борхуйд бүхий манж цэргийг өгч, 8 сарын 24-нд Завхан дахь ойрадуудыг бариулахаар илгээж, залгамжилж Арантай, Жаохуй, Намжил, Шүхэдэ нар солон цэргийг авч орохоор тогтов.¹¹

⁶ *Зарлигаар тогтоосон Зүүнгарын газрыг төвиштгөн тогтоосон бодлогын бичиг*, 1770 (Бээжин бар). Жинхэнэ зохиол. Дэвтэр 20. ТТ20 он (1755)-ы 10 сарын хөх хулгана өдрийн зурвас. Тус сурвалж бол 1770 онд Манж Чин улсын Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигаар манж, хятад хоёр хэлээр барлан тархагдсан. Гарчиг болон өмнөд (54 дэвтэр), жинхэнэ (85 дэвтэр), дараа зохиол (32 дэвтэр) хэмээх гурван бүлэг, 171 дэвтрээс бүрддэг. Эдүгээ Зүүнгарын бодлогын бичгийн манж эх нь Монгол, БНХАУ, Япон, Франц зэрэг орны номын сан, эрдэм шинжилгээний байгууллагуудад хадгалагдаж буй бөгөөд сүүлийн үед дэлхийн дахинд онлайн номын сан хөгжсөнөөр тус сурвалжийн манж эхийг олж үзэх боломжтой болов. Gallica <http://gallica.bnf.fr/>. 2020.1.5.

⁷ *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 17. ТТ20 он (1755)-ы 9 сарын улаан хулгана өдрийн зурвас.

⁸ МУУТА, М-180. Д-1. Хн-34. Б-1.

⁹ *Шинжааны данс*, Боть 12. ТТ20 он (1755)-ы 9 сарын шинийн 6-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 393.

¹⁰ *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 17. ТТ20 он (1755)-ы 9 сарын хөхөгчин гахай өдрийн зурвас.

¹¹ *Шинжааны данс*, Боть 12. ТТ20 он (1755)-ы 9 сарын шинийн 6-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 392.

Харин энэ үед буюу 8 сарын 24-нд Амарсанаагийн зайсан Мэнд, Амаржаргал нарын араас илгээсэн их мянганы тайж Банжуур халхын нутагт ирж, түүний хатан Дэлэгдорж, ах Жамц нарт Амарсанаа нэгэнт бослого гаргахаар тогтсон болохыг мэдэгдсэнд, тэд мал хуй, зэр зэвсгийг бэлтгэж, 8 сарын 25-ны өглөө зайсан Амаржаргал, Баяр, Бэхлэгч, Эв нарын хамт харьяат арван гурван хошууны албатыг авч¹² оргохоор бэлтгэж бүхийд, тухайн үед Завханы газарт ном уншиж байсан халхын лам Ноёнцорж, Амарсанаагийн лам Чүрүмбанжуурт хувцас хунар өгч олныг тогтоотугай хэмээн ухуулж, тэднийг зогсоосноор халх дахь Амарсанаагийн гэр бүл, албатууд хөдөлсөнгүй.¹³ Манжийн төрөөс энэхүү лам Ноёнцоржийн байгуулсан гавьяаг өндрөөр үнэлж, хишиг хүртээж *Чин сүжигт номун хан* цол, тамга шагнаж өгсөн билээ.¹⁴

Чингээд өмнө одсон мэйрэний занги Пүкиний цэрэг цөөн, хүч нэмж ирэх солон цэргийн унах морь зам хол улмаас хурдан хүрч ирж чадахгүй учир засаг Сүндүвийг авч, зам зуур халхын бэйл Намжил, Фэфүг дайчилж 8 сарын 25-нд Завханы нутагт хүрч Дэлэгдорж, Жамц, Банжуур нарын 400 гаруй адууг хурааж авсанд, Улиастайгаас мэйрэний занги Даш 40 цэргийн хамт маргааш өдөр нь гүйцэж иржээ.¹⁵ Тэд 8 сарын 27-ны шөнө хүч нэмж ирсэн манж, цахар цэргийг тэгшилж хойд, хошууд нарыг дайлахаар бэлтгэж бүхийд, Дэлэгдорж, Жамц, Банжуур нар, манжийн хиа Фүлиян, Элдэнгэ нарт элч илгээж;

*...Амарсанаа эзний хүнд хишигийг хүлээж чадахгүй учир дэмий явав, тэр манд хамаагүй. Эдүгээ сайдууд цэрэг авч ирэх учирт бид машид аймуй. Бид гагцхүү эзнийг гуйж одмуй, өөр санаагүй.*¹⁶

хэмээсний хариуд, Жаохуй, Фэфү нар тэднийг ирэхийг тушаасанд, Амарсанаагийн хатан Дэлэгдорж хуувийн сайд Жаохуйд;

¹² Амарсанаа, Нэмэх нарын Орхон, Тамирын газар өвс, ус муу тул тэдний хамт дагаж ирсэн ойрадуудыг нүүлгэх хүсэлтийн дагуу мэйрэний занги Намжил, Сайн ноён аймгийн туслагч жанжин, жүн ван Дэчинжавын цуг 1755 оны 4 сарын 17 Амарсанаа, Банжуур нарын харьяатыг Тамираас нүүлгэж, 5 сарын 22-нд Гурван шөрөгийн газарт нүүлгэсэн байна. Мөн халхын гүн Цэвээн нар, дөрвөдийн Нэмэхийн арван хошууны нутгийн ардыг 5 сарын 12-нд, Завханы эх Бор хавцлаас Орхай, Шар усны газарт нүүлгэсэн байна. *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 13. ТТ20 он (1755)-ы 6 сарын цагаан нохой өдрийн зурвас.

¹³ *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 19. ТТ20 он (1755)-ы 9 сарын улаагчин тахиа өдрийн зурвас.

¹⁴ Мөн тэнд.

¹⁵ *Шинжааны данс*, Боть 12. ТТ20 он (1755)-ы 9 сарын шинийн 6-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 392.

¹⁶ Мөн дээрх. [... amursana ejen i ujen kesi be alime muterakū ofi balai yabuha. ei mende dalji akū. te ambasa сооha gajire jakade be umesi gelembi. be damu ejen be baime genembi. güwa günin akū]. 392-393.

... Бид өнгөрсөн жил [1754] дагаж орсон цагаас эзний хишигийг хүртсэн нь тооловч барахгүй. Амарсанаа тэрслүү хулгай мэт дэмий явсан нь тухайлан хүнд хишигийг хүлээж эс чадах тул буюу. Тэр надаас өөр эхнэр авч маньг гээсний тул, би юунд түүнийг эрж одох. Би эдүгээ өөрийн хүүхдийг авч Банжуур нарын цуг яаравчлан эзний дэргэд одсугай. Мань албатыг миний хүүд залгамжлуулах, эс бөгөөс хэрхэх явдлыг хишиг эзнээс гармуй. Би чин хэмээн бурханд залбирч, эзний хишигт жаргаж аж төрсүгэй хэмээн гуймуй.¹⁷

хэмээгээд, түүний албатын дотроос оргож зугтахыг үгүйсгэхгүй тул Орхон, Тамирын газарт нүүлгэхийг хүсэв. Үүнд, Дэлэгдоржийн хүсэлтийг ёсоор болгож, Завхандах ойрадуудыг Орхон, Тамирт нүүлгэхэд цахар, халх 200 цэрэг гаргаж, халхын бэйл Намжилцэсүрэнд хариуцуулан хүргүүлэх, харин Амарсанаагийн хатан, хүү хоёрыг хиа Фүлиянд тушааж, Бээжинд хүргэхээр тогтжээ.¹⁸ Үүнээс гадна, нийслэл хотын манж цэрэг, Хар мөрний солон цэргийг захирах Даш, мэйрэний занги Пүкин нарыг түр Завханы газарт сэргийлэн суулгаж, Амарсанаагийн харьяатыг дотогш нүүлгэсний дараа Хөх даваа, Нам давааны газрыг сэрэмжлүүлэхээр тогтов.¹⁹ Улмаар хойд, хошууд нарын морь мал, зэр зэвсгийг хурааж, зөвхөн хүнсний хонь өгч Орхон, Тамирт нүүлгэсэн ба Амарсанаагийн гэр бүл оргохоор төлөвлөснийг Ринчиндоржид мэдэгдсэн хойдын бэйл Чимхүүрт түүний албатаас 100 өрх ам, мөн Амарсанаагийн хатан Дэлэгдорж, Нэмэхийн эгч тул түүний хоёр охиныг Нэмэхэд шагнаж²⁰, үлдсэн

¹⁷ *Шинжааны данс*, Боть 12. ТТ20 он (1755)-ы 9 сарын шинийн 6-нд улаан бийрээр цохолсон айлтгал. [... be duleke aniya dahame dosika ci ejen i kesi be alihangge toloho seme wajirakū. amursana fudasi hūlha gese balai yabuhangge cohome ujen kesi be alime muterakūngge. ei tulergi de encu sargan gaifi membe waliyaha be dahame bi aiseme imbe baime genembi. bi te mini juse be gaifi banjur sei sasa hahilame ejen i jakade geneki. mini albatu be mini jui de salibure, eici adarame obure babe kesi ejen ci tucimbi. bi hing seme fucihī de jalbirame, ejen i kesi de jirgame banjiki seme erembi]. 392-393.

¹⁸ Амарсанаагийн гэр бүл цаашид хэрхсэн талаар 1755 оны 10 сарын 15-нд Бичгийн эрхин сайд, хиа захирах дотоод сайд, итгэлт баатар гүн Пүкин нарын Тэнгэрийн тэтгэсэн хаанд айлтгасан айлтгалд, хиа Сэлэнгэ, нийлэн шүүгч Гүвамбоо нар Амарсанаагийн хатан, Нэмэхийн гэргийг хаана суулгах талаар айлтгажээ. Тус айлтгалын хариуд, Манжийн төрөөс Амарсанаагийн хүү Данжиндаржагийн нэг газарт эс суулгах, Шүүх яаманд тушааж хорих шийдвэр гаргаснаас өөр одоогоор тодорхой сурвалжийн мэдээ олж үзсэнгүй. *Шинжааны данс*, Боть 21. ТТ20 он (1755)-ы 10 сарын 15-нд Пүкиний айлтгасан айлтгал. 192.

¹⁹ Үүнд, халхад бүхий Амарсанаагийн албатуудыг Орхон, Тамирт нүүлгэхэд манжийн сайд, түшмэд, хиа нар, цэрэгт 2500 гаруй морь шийтгэж өгчээ. БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив, *Цэргийн тухайн газрын манж айлтгалын эвхмэл*, ТТ20 он (1755)-ы 10 сарын 16-нд улаан бийрээр цохолсон айлтгал.

²⁰ *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 18. ТТ20 он (1755)-ы намар 9 сарын харагчин хонь өдрийн зурвас. Мөн Амарсанаа, Банжуур, Гэндэнжавын нутгаас хурааж авсан 396 тэмээ, 1853 морь, 89 буу, 39 иж саадаг, 41 нум, 20 илд, 9 жад, хуяг нэг ижийг засаг Сүндүвт хариуцуулж Улиастайн цэргийн хүрээнд хүргүүлж, үлдсэн эд зүйлсийг Чимхүүрийн зайсан нарт хувааж шагнаснаас гадна, Амарсанаагийн 1600 лан мөнгө, ганжуур судар нэг иж, гурван бурханыг хөөгч Чүнбоод тушааж Бээжинд хүргүүлсэн байна. *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 20. ТТ20 он (1755)-ы өвөл 10 сарын шарагчин туулай өдрийн зурвас.

өрх албатыг Түнхэнхоюурт нүүлгэхээр шийдвэрлэсэн авч²¹, тэднийг нүүлгэхэд цэрэг, морь мал, хүнс зэрэг зардал гарах тул, Тэнгэрийн тэтгэсэн хаан хойд, хошууд нараас Халхын дөрвөн аймагт хуваан шагнах зарлиг буулгав.²²

Ийнхүү Амарсанаа Илд давшсан цагаас халх дахь хойд, хошууд нарыг Зүүнгат нүүлгэхээр бэлтгэж байсан боловч²³, амжилт эс олсон ба тус Завханд байсан ойрадууд нь Амарсанаагийн харьяат албатаас гадна, Убаш, Зан, Дэрбэшил зэрэг 20 гаруй зайсангийн гэр бүл, албатууд байв.

2. Буучин отгийг хядсан тухай

Дээрх үйл явдалтай зэрэгцээд, Амарсанааг нэхсэн гүн Лимпилдорж, орлон хөөгч Чигшин, хөх отго Юндэ, Удай, халхын занги Ямпил нарт, 1755 оны 8 сарын 21-ий шөнө Чингэл гэх газарт баригдсан зайсан Бямба²⁴, Баатар, Халчаа, Ууль, Данжин нарын өчсөнчлөн²⁵, буучин отгийн бүгдийн дарга Агзул, дэд дарга Тайлаг нар²⁶ халхад бүхий Амарсанаагийн гэр бүл, албатуудыг угтахаар тус оны 8 сарын сүүлээр [барагцаалбал 24-26 хооронд] 2000 гаруй албатын хамт Хажунгуй гэх газраас Ховд, Буянтын ойр Солби, Улаагчины даваагаар Алтайг давж, Булган, Цагаан тохойн зүг одсон учир бүгдийн дарга Обошид 500 солон цэрэг өгч, тэднийг нэхүүлж, давхар Улиастайн цэргийг чухал хавцал амд илгээж сэргийлүүлэв.²⁷

Амарсанаагийн тушаасны дагуу Завхан дахь ойрадуудыг угтахаар Алтайг давж, манжийн харуулын хиа, цэрэг, хөтөчийг хороосон буучины бүгдийн дарга Агзул, дэд дарга Тайлаг, шүүлэнгэ Эсэмбэй нар 1755 оны 8 сарын 29-нд Булган эхийн газарт Талмашан, Жаланга нарын цэрэгтэй таарсанд²⁸, Агзулыг амьд барьж, тус отгийн 10 наснаас дээш эрсийг устгаж²⁹, охид эмэгтэйчүүд, 10 нас хүртэлх

²¹ *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 19. ТТ20 он (1755)-ы намар 9 сарын шар нохой өдрийн зурвас.

²² Мөн дээрх.

²³ Жамбалдорж, Ц. “Амарсанаагийн бослогын эхлэл: Сурвалж ба судалгаа”, *1755-1758 оны Манжийн эсрэг Монголчуудын зэвсэгт тэмцлийн түүхийн асуудал*, Улаанбаатар, 2019: 103-104.

²⁴ Ташрамд дурдахад, энд нэр гарах Бямба, тайж Норовын хүргэн тул Бямбыг нутагт аваачсан байсан авч, 1756 оны хавар Норов нас барахад, Бямбыг Жалафунгад тушааж, цэргийн хүрээнд аваачиж цаазаар авсан ажээ. *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 27. ТТ21 он (1756)-ы 4 сарын шар морь өдрийн зурвас.

²⁵ МУУТА, М-180. Д-1. Хн-24. Б-1. Халхын зүүн гарын цэргийг захирах туслагч жанжны тамгыг хамаарсан засаг төрийн жүн ван Санзайдоржийн бичиг.

²⁶ 1754 оны намар Амарсанаагийн саналын дагуу, Манжийн төрөөс буучин отгийн долоон дэчиний 659 өрхийн 2819 амыг цэрэг илгээн дагуулсан билээ *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 6. ТТ20 он (1755)-ы 1 сарын шар нохой өдрийн зурвас.

²⁷ МУУТА, М-180. Д-1. Хн-33. Б-1.

²⁸ Энэхүү буучин отгийн бүгдийн дарга Агзулыг барьсан Жав, хулгай нарыг хороосон Аюуш, Бани, Пунцаг нарт Манжийн төрөөс 50 лан мөнгө шагнажээ.

²⁹ 1754 оны намар Манжийн төрөөс буучины зайсан Чомоны 900 гаруй өрх албат (1 өрхийг 5-6 хүнээр тооцвол 5000-6000 ам)-ыг дагуулж, Чомоны ах Агзулыг бүгдийн дарга тавьж буучин

хөвгүүдийг жанжин сайд, солон, халх нарт *олзны хүн* (хөвгүүд, охид, эмэгтэйчүүд), *зэр зэвсэг* (буу, нум, саадаг, олбог, жад, илд гэх мэт), *мал* (тэмээ, морь, үхэр, хонь) гэсэн 3 төрөлд хувааж, хэргэм зэрэг, устгасан дайсны тоо, шархадсан эсэхийг харгалзаж тус отгоос үлдсэн 1000 гаруй амыг хуваан шагнажээ.³⁰ Үүнд, солон нарт 10 наснаас доош хөвгүүд, зэр зэвсэг, морь тэмээ, харин халхуудад охид, эмэгтэйчүүдийг боол болгож өгсөн аж.³¹

Тийнхүү 1755 оны 8 сарын 29-нд халх дахь хойд, хошууд нарыг угтахаар Алтайг давсан буучин отгийн хүн ам Талмашан, Жаланга нарын цэрэгт хядагдсан нь ойрадуудыг отгоор нь устгаж, хүүхэд эмэгтэйчүүдийг нь боол болгосон анхны тохиолдол байв.³²

отгийн хүн амыг захиргасан билээ. *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 17. ТТ20 он (1755)-ы 8 сарын цагаан бөч өдрийн зурвас.

³⁰ БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив, *Цэргийн тухайн газрын манж айлтгалын эвхмэл*, ТТ20 он (1755)-ы 9 сарын 24-нд улаан бийрээр цохолсон айлтгал. Тухайлбал, буучин отгоос амьд үлдсэн 563 хүүхэд, эмэгтэйчүүдээс чин ван Цэнгүнжав, тугийн занги Талмашан, мэйрэний занги Жаланга нарын цэрэгт 143 хөвгүүд, 370 охид, эмэгтэйчүүд, хиа Монголдойн цэрэгт 17 хөвгүүд, 33 охид, эмэгтэйчүүдийг тус тус шагнасан бол халхын бэйл Шагдаржав, гүн Дамиран нарт буучины 295 амыг хуваан шагнаж, чин ван Санзайдорж, чин ван Цэнгүнжав зэрэг гавьяа байгуулсан халхын тайж нарт тус отгоос үлдсэн хүүхэд эмэгтэйчүүд, настайчуудыг дотор газарт нүүлгэн шилжүүлэхэд илүү зардал сүйтгэл гарах тул ийнхүү хуваан шагнаж шийдвэрлэсэн буй.

³¹ Манжийн төрөөс буучин отгийг устгахад гавьяа байгуулсан, жүн ван Базаршидийг чин ван, бэйс Шагдаржавыг бэйл, гүн Даржаа, Норовжавыг бэйс, туслагч тайж Дамиранг гүн өргөмжилжээ. *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 18. ТТ20 он (1755)-ы намар, 9 сарын шар хулгана өдрийн зурвас. Үүний дээр, Дээрхээс гадна, тугийн занги Талмашан, мэйрэний занги Жалангаад тус бүр 3 хөвгүүн, 5 хулгайг алсан дэд дарга Омбод хөвгүүн 2, буу, илд, жад, саадаг тус бүр нэжгээд, орлон хөөгчийг орлосон залны занги Сэлтэнд 3 хулгайг алсан учир хөвгүүн 1, жад, илд, саадаг тус бүр 1, орлон хөөгчийг орлосон залны занги Доргилтод 2 хулгайг алсан гавьяаг үнэлж хөвгүүн 1, буу 1, илд 1, залны занги Балхунд мөн 2 хулгайг алсан тул хөвгүүн 1, буу 1, илд 1, сумын зангийг оролж, хэл барьсан залны занги Мишүнд хөвгүүн 1, буу 1, илд 1, сул занги Хамарт хөөгчийг орлосон тул хөвгүүн 1, буу 1, илд 1, залны занги Зээлтэд 1 хулгайг алж, орлон хөөгчийг орлосон тул хөвгүүн 1, буу 1, цэрэг авч өмнө явж, дэд даргыг орлосон хүрээний дарга Заркид хөвгүүн 1, буу, илд, тус бүр 1, мөн цэрэг авч өмнө явсан хүрээний дарга Олдайд хөвгүүн 1, буу 1, сумын зангийг орлосон Лорбүнайд хөвгүүн 1, буу 1, цэрэг авч өмнө явсан сумын занги Сэхитэд буу, жад, нум тус бүр нэжгээд, орлон хөөгчийг орлосон залны занги Эрүүнд буу, жад, нум тус бүр нэжгээд, 6 хулгайг алсан хөвөөт шарын сумын хуяг Нахамбоод хөвгүүн 2, буу 2, саадаг 1, 4 хулгайг алсан шулуун шарын сумын хөөгч Пэйжлүний зэрэг 2 хүнд хөвгүүн 1, буу, илд, саадаг хүн тус бүр нэжгээд, 3 хулгайг алсан хөвөөт шарын сумын хуяг Дамбүрийн эзэрг 9 хүнд хүн тус бүр хөвгүүн 1, буу 1, 2 хулгайг алсан шулуун шарын сумын хөөгч Антабогийн зэрэг 9 хүнд хөвгүүн 1, буу 1, мөн 2 хулгайг алсан хөвөөт шарын сумын орлон бичээч Гэсэндэйн зэрэг 25 хүнд хүн тус бүр хөвгүүн 1 гэх мэтчилэн Манжийн төрөөс буучин отгоос үлдсэн 1000 гаруй ам, зэр зэвсгийг нэг бүрчлэн гавьяа байгуулсан халх, солон цэрэгт хуваан шагнажээ.

³² Энд буучин отгоос зугтаж гарсан хүмүүсийг нэгжиж барьсан тухайд, 1755 оны 11 сард Цагаан гол, Булган, Халбацагийн газарт хайгуул хийж явсан манжийн цэрэг Халбацагийн газарт тус отгоос зугтаж гарсан 6 өрхийн ардтай учирч довтлон дагуулж, зугтаж гарахыг завдсан нэг өөлдийг солони орлон хөөгч Аюуш харван алж, 7 эрийг алж, 18 хүнийг амьд барьсан байна. Үүний дээр, Булган голын газарт буучины 12 хүн модон дотор нуугдсаныг үзэж, шууд довтолж 4 эрийг хороож, 1-ийг амьд барьж газарчлуулж, тэдний нуугдсан газрыг заалгаж эм хүүхэд 7-г

Буучин отгийн эрсийг устгахын сацуу, тэдний 132 тэмээ, 1480 морь, 1572 үхэр, 17260 богоор түшмэл цэргийн морь хүнс залгамжлуулсныг Тэнгэрийн тэтгэсэн хаан сайшааж, Юнчан, Цэрэн, Жалафунга нарт цэрэг тэгшилж Зүүнгарт давшиж, энэ мэт ойрадуудыг цөм дээрх адил шийтгэх буюу Амарсанааг дагаж бослого гаргасан отгуудын эрсийг хядаж, хүүхэд эмэгтэйчүүдийг гавьяа байгуулсан хүмүүст хуваан шагнаж, тэдний малаар цэргийн хүнс, унаа залгамжлуулах зарчмаар Амарсанаагийн бослогыг дарах зарлиг буулгав.³³

3. Амарсанаагийн бослогыг дарахад бэлтгэсэн нь

Хойдын тайж нар болоод, Өрөнгөөс баригдсан ойрадуудаас авсан мэдээллийн дагуу Улиастайн хэргийг шийтгэх сайд Арантай 1755 оны 8 сарын 20-29 хооронд, Халх дахь хойд, хошууд нар болоод буучин отгийг Амарсанаатай нэгдэхийг зогсоож чадав. Улмаар Үрүмчид суух Юнчанаас 1755 оны 8 сарын 21-нд өрнө замын өртөө, ойрадуудын нөхцөл байдлын мэдээг авуулахаар Аминдоо, Карна нарыг илгээснийг Тэнгэрийн тэтгэсэн хаан сайшааж, түүнийг *Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин* (хойшид ХДТЗЭТЖ гэж товчилно) болгож, Цэрэн, Юйбоо, Жалафунга нарыг хуувийн сайдад томилж, тасарсан өртөөг залгамжилж, Банди, Оёнгу нартай холбоо тогтоох зарлиг буулгав.

Үүний дээр, буучины Агзул ойрадууд Банди, Оёнгу нарыг довтлох, хасагаас Амарсанаад цэргийн тусламж ирэх тухай өчсөн тул, Тэнгэрийн тэтгэсэн хаан, Амарсанаа ойрадуудыг өөртөө татаж авахаас урьтахыг илүүд үзэж, богино хугацаанд 7000-8000 цэргээр Зүүнгарт довтолж, Илд үлдээсэн халх, цахар 500 цэрэгтэй хүч хавсарч бослогыг дарах зарлиг буулгасан тул манжийн жанжин сайдууд хоёр замын цэргийг Улиастай, Бархөлд цуглуулж эхэлсэн байна. Тийн авч Зүүнгарыг дайлж, морины хүч цуцсан, мөн хоёр замын цэргийг буцаан татсан үед Илд цэрэг илгээх, Алтайг давах чухал хавцал, даваанд сэргийлэх цэрэг суулгах, халхад бүхий ойрадуудыг харгалзах гэх мэт нэгэн зэрэг олон цэрэг хэрэгсэх шаардлага тулгарснаас гадна, тэдний унах морь, идэх хүнсийг залгамжлуулах нь тийм амар шийдэгдэх асуудал бус байв.

хураан авч, цааш явж Монцогт гэх газраас буучины 12 хүн нуугдсаныг барьж 4 эрийг хороож, 8 амыг олзолж, Өрөнгийн замаар явж, Хочис гэх уулын дотор нуугдсан буучины ардтай таарч 44 эрийг алж, 47 хүүхэд эмэгтэйчүүдийг олзолж, 10 тэмээ, 76 морь, 12 буу, 4 илд, 1 жадыг хураан авсан байна. Мөн Хочисийн газарт суусан галзадын 5 өрхийн 55 амыг хураан авч, нийт 119 амыг олзолж авсан байна. *Шинжааны данс*, Боть 10. ТТ20 он (1755)-ы 11 сарын 30-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 72-75.

³³ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын 11-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 122-125.

Гэтэл өртөөг залгамжилж, Илд цэрэг давшихыг хариуцуулсан Юнчанаас, өрнө замын өртөөнөөс гадна, Зүүнгараас нутагт буцсан гүн Миншүй нарын халхууд ойрадуудад цохигдсон, мөн Амарсанаа, Авгас, Хадаан нарт хүч залгамжилж, *Эрээн хавиргын тайж нарыг довтолж ирнэ* гэх мэдээ буй тул бүгдийн дарга Билгүүнд солон, баргын цэргийг татахыг хойшлуулахыг тушааж, харьяат захирах 500 цэргийг Үрүмчээс татаж, арав гаруй хоног явж, 8 сарын 27-нд Муруйд ирэв, Илийн мэдээг авч эс чадсан тул тэсгэлгүй аймуй хэмээн айлтгав.³⁴ Үүнээс гадна, захчины 1000 гаруй хүн дагаар ирэхээ мэдэгдсэнийг эс айлтгасан тул, 1755 оны 9 сарын 15-нд Юнчаныг жанжинаас байлгаж, оронд нь манж түшмэл Цэрэнг ХДТЗЭТЖ болгож, Юнчаны айлтгасан Галсандоржийн хүү Норовринчин, Авгас, Хадааныг цохьсон мэдээг авах, өрнө замын өртөөг залгамжилж, Эрээн хавиргын тайж нараас цэргийн хүчийг зузаатгах зарлиг буулгав.³⁵

Чингээд өвлийн хүйтнээс урьтаж Зүүнгарт довтолж, Амарсанааг барихаар бэлтгэж эхэлсэн авч хоёр замын цэрэгт олгох хувцас хунар, цалин хөлс, хүнс зөөх тэмээнээс гадна, хамгийн чухал нь Илд давших 7000 (хамгийн багадаа 1 цэрэгт 2-3 морь) цэргийн унах морийг богино хугацаанд залгамжлуулж эс чадах тухай жанжин Цэрэнгийн айлтгалын хариуд, Тэнгэрийн тэтгэсэн хаанаас 1755 оны 9 сард буулгасан зарлигт;

*... Цэрэн энэ хооронд цэрэг морийг тэгшилж орвоос болох мэт болбаас даруй давшин орж Жалафунга, Юйбоо бас эдний авч ирсэн зайсан нар хүрч ирж бүгд нэг санаагаар зөвлөлдөж Авгас, Хадааны зэрэг ардыг барьж, шууд Илд хүрч хулгайг арилгатугай. Зүүнгарын ардын төлөвийг үзвээс хялбараар хувьсч самуурчээ. Бидний нэг хэдэн хүн шаламгайлж шургачин орвоос тэр даруй айж сарнимуй.*³⁶

³⁴ *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 17. ТТ20 он (1755)-ы 9 сарын улаан хулгана өдрийн зурвас. Үүнээс гадна, тус бослогын хөлөөс зугтсан нэг хэсэг ойрадууд Бархөл, Хами зэрэг газарт ирж, Манжийн төрөөс идэх хүнс, түр нутаглах газар хүсч байв. Жишээ дурдбал, 1755 оны 9 сард жанжин Юнчаны газраас өрнө замын их мянганы зайсан Жамц нарын хоёр хүн, бүгүнүдийн дэмч Баатархошууч зэрэг дөрвөн хүн, Дондогийн дүү Орхимж зэрэг хүмүүс дагаж ирсэн тухай тус оны 9 сарын сүүлээр Тэнгэрийн тэтгэсэн хаанд айлтгасан буюу Юнчан тэднийг Амарсанааг дагаж оргосон Эрээн хавиргын зайсангуудын мэдээг авах хэрэгт дайчлан ашиглаагүй, мөн Амарсанаа яг хаана байгаа тухай баттай мэдээг аваагүй тул энэ жил бус хойт жил цэрэг орох санал гаргасан нь түүний өрнийг тогтоох жанжны тушаалаас огцруулах бас нэг шалтгаан болсон буй. *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын шинэд, Юйбао, Үлдэн нарын айлтгал. 120-121.

³⁵ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын шинийн 9-нд бийрээр цохолсон айлтгал. 112-115.

³⁶ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 9 сарын Цэрэнгийн айлтгал. [... zeren ere sidende cooha morin be teksilefi dosici ojoro gese oci uthai ibeme dosime jalafungga, ioi boo, jai esei gaifi gamaha jaisang se isinafi uhei emu gūnin i hebešeme abugas, hadan i jergi urse be jafame, šuwe ili de isiname hūlha be geterembukini. jun gar i ursei muru be tuwaci ja i kūbulime facuhūracibe. musei emu

хэмээн, урьдаар мэйрэний занги Аминдоод 200 цэрэг өгч Илд илгээж Банди, Оёнгу нарын мэдээг авах, хүн бүр авсан мэдээг цаг тухайд хаанд айлтгах, хурдан хоёр замын цэрэгт морь хүнс залгамжилж илгээхгүй болбаас халхад бүхий дөрвөд, баядууд давхар бослого, үймээн гаргаж болзошгүй тул анх тогтоосон 7000 цэрэг бүрдэхийг хүлээлгүй, 3000-4000 цэрэг цугламагц Зүүнгарт давшихыг зарлиг болгосон байна.³⁷

Энэхүү Тэнгэрийн тэтгэсний зарлигийн дагуу Цэрэн ногоон тугийн цэрэг дайчлахыг байлгаж, тэдний морийг татаж, манж, солон, халх цэрэгт олгож, чадах чинээгээр захчины ард, Авгас, Хадаан нарыг Амарсанаатай нэгдэхээс сэргийлэх, Эрээн хавиргын Норовринчин, Хасагшар нараас цэргийн хүнс, морь мал залгамжилж, аль болох хурдан Зүүнгарт давшиж, бослогыг дарахыг хичээж байв.³⁸ Үүнд, Сүжөү, Ганьжөүгийн хятад цэргээс хүрээ тутам мянгыг татаж, дайчлан захирагч сайд Дөү Биньд хариуцуулж Бархөлд сүр хийн суулгаж, Зүүнгарт давших хоёр замын цэргийн хэрэглэлийг Хамид бэлтгэхийг бүгд захирагч сайд Лю Түншюньд хариуцуулав.³⁹

1755 оны 9 сарын сүүл буюу Амарсанаа Халуунаас зайлах ордонд очих зам зуураас зугтсанаас нэг сар орчмын дараа Улиастайд цуглуулсан умард замын *солон* (цэрэг 2015, морь 856, тэмээ 139), *цахар* (цэрэг 1889, морь 370), *халх* (цэрэг 1090, морь 900)-аас татсан 4994 цэрэг, 3645 морь, 509 тэмээг 10 сарын шинийн 2-нд мэйрэний занги Хурки Улиастайгаас Бархөлд авч ирэв.

Улмаар Цэрэн, Хоки нар зөвлөлдөж дээрх халхын 1090 цэргээс морины тоог харгалзан үзэж 300 гаргах, цахар цэрэг, солон цэргээс цөөн учир цахар цэргийн 1889 морийг солон цэрэгт татаж өгөх, мөн өртөө улаа залгамжлуулахад бэлтгэж Улиастайд үлдээсэн 2000 мориноос эцсэн 800-г хасч, үлдсэн мориноос 300-г сонгож, солон, цахар цэргийн 2745 морин дээр нэмж, нэг цэрэгт 2-3 морь унуулахаар тооцож солон цэргээс 1015 гаргахаар тогтов.⁴⁰ Харин цэргийн хүнс зөөхөд хүч тэвээргийг харж 260 тэмээ сонгож, бусад ачиваас болох 509 тэмээг хоёр замын цэрэгт зохихыг үзэж нөхөн олгож⁴¹, халх, солон, цахарын цэргийг

udu niyalma fafuršame funturšeme dosici, ei uthai gelefi samsimbij].

³⁷ Мөн дээрх. 126-127.

³⁸ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын 11-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 138.

³⁹ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын шинийн 6-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 141-142.

⁴⁰ БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив, *Цэргийн тухайн газрын манж айлтгалын эвхмэл*, ТТ20 он (1755)-ы 10 сарын 16-нд улаан бийрээр цохолсон айлтгал.

⁴¹ Мөн дээрх.

дараах хүмүүст захиргасан байна. Үүнд, халхын цэргийг гүн Цэдэнсампил, Бадамсэнгээ, солоны цэргийг мэйрэний занги Даш, Хурки, цахар цэргийг Бэхи, Сандүв нарт захиргасан бол үлдээсэн халхын цэргийг бэйл Шагдаржав, солоны цэргийг хамтатгаж захиргасан Омбыг зарлигаар Жалангаагийн ангийн солоны цэргийг удирдуулж илгээсэн тул, хоцоргосон 1000 солон цэргийг бүгдийн дарга Обошид захируулж, харуулыг сэрэмжлүүлж, морь малыг адуулуулж суулгажээ.⁴²

Үүний дээр, Юйбоо, Үлдэн нар ойрадын тайж нарын морь малыг үлдээсэн Борхажийн газарт хүрээд солон цэрэгт нэмж олгох агт морь цөм туранхайн улмаас Бархөлд хүрч чадахгүй тул цэргийн хүнсэнд бэлтгэсэн гүүнээс хүч тэвээргийг харж солоны цэрэгт өгч, Юйбоо, Үлдэн, Өлзий, Лхасүрэн, Дашцэрэн, Өжэт нарт солон цэргийн адил, тэдний эцсэн морины оронд гүү халж унуулав.⁴³

Бас 1755 оны 8 сард буучин отгийг устгаад, Солби, Улаагчины наана суусан солон, халх 1500 цэргээс 1000-ыг мэйрэний занги Жаланга авч, чин ван Цэнгүнжав, тугийн занги Талмашан, бэйс Даржаа нарын хамт залгамжилж орох, үлдсэн халхын 500 цэргийг чин ван Базаршид авч Ховд, Буянтын зэрэг газрын цэрэгт хүч нэмж харуулын цонж тавиулж, шинэ, хуучин урианхайн нутгийг хамгаалж, Алтайг давах чухал ам хавцлыг сэрэмжлүүлж суулгахаар болжээ.⁴⁴

Харин Бархөлд цугласан өрнө замын 2000 гаруй цэргийн унах морины талаар 9 сарын 28-нд жанжин Цэрэн;

*... Байцааваас дайчилж авч ирсэн 5400 морь гэгч цөм хаврын улиралд түшмэл цэргийн унаж ирсэн, халсан эцсэн морь бөгөөд хүч сайн нь буй. Басхүү хүч нэмнүү нь мөн буй. Үүний доторт унасан, огт унаваас эс болохыг тооцож бүгд 4909 морь сонгож, бас анги ангийн хуучин мориноос сонгосон хүч сайн морь бүгд 4435 морийг харгалзан үзэж, 2380 цэргийг томилж, 300 баатар цэрэгт хууль ёсоор хүн тутам гурваад морь олгосноос гадна, бусад цэрэгт хүн тутам түр хошоод олгож, сайд, түшмэдэд мөн хагаслан олгож шийтгэжэхүй.*⁴⁵

⁴² БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив, *Цэргийн тухайн газрын манж айлтгалын эвхмэл*, ТТ20 он (1755)-ы 10 сарын 16-нд улаан бийрээр цохолсон айлтгал.

⁴³ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын шинийн 4-ний Юйбоо, Үлдэн нарын айлтгал. 150-151.

⁴⁴ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын шинийн 4-ний Хадаха, Арантай, Шүхэдэ нарын айлтгал. 154.

⁴⁵ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын шинэд, Цэрэнгийн айлтгасан айлтгал. [... baicaci fideme gajiha sunja minggan duin tanggū morin serengge gemu niyengniyeri forgon de hafan coohai yalume jihe halaha šadaha macuka morin ofi, yali sain ningge emu bi. kemuni yali jokson ningge inu bi. erei dorgide tuheke fuhali yaluci ojarahunge be sufi uheri duin minggan uyun tanggū uyun morin bahafi geli meyen meyen i fe morin i dorgici sonjoho yali sain morin uheri duin minggan duin

хэмээн умард замын адил морины тоог харгалзан үзэж, цэрэг томилсон тухай айлтгав.

Өрнө замын цэргийн хүнс зөөх тэмээний тухайд, шинээр татсан 499 тэмээн дээр, цэргийн хүрэнээс сонгож гаргасан хуучин буюу 1755 оны хавар Зүүнгарыг дайлахад дайчилсан 226, нийт 725 тэмээг өрнө замын цэрэгт олгосон байна. Гэвч энэ удаад татсан морь, тэмээнээс зам зуур 2000 гаруй морь, 300 орчим тэмээ хорогдсон тул энэ тухай Хоки, Дөү Бинь нарт мэдэгдэж, цэргийн хүрээнд цугласан морь, тэмээнээс тооны ёсоор нөхөж өгөх, мөн өмнө орох түшмэл цэрэг зөвхөн нэг сарын хүнстэй тул хүргэж ирсэн амуунаас зохихыг үзэж нэмж олгохоор болов.⁴⁶

Түүнчлэн солон 1500, шилдэг хурцат хүрээний халх, хотгойд 500, цахар 380 цэргээс 200 цэргийг мэйрэний занги Аминдоо авч түрүүлж орох, бэйл Цэмцүгжав, гүн Ванбуудорж, мэйрэний занги Сангэ, бүгдийн дарга Билгүүн, хиа Чинүхун, Мачан, туслан захирах дарга Карна нар үлдсэн цэргийг тус тус авч орохоор тогтов.⁴⁷

Дээрх мэт Илд давших хоёр ангийн цэрэг бэлэн болж, Бархөлд хүрсэн авч бүгд захирагч сайд Лю Түншюнь цэрэг, морь, хүнсний талаар;

*...Бархөлд хүрч ирэв. Дэд өдөр олон сайдуудыг цуглуулж цэрэг бэлтгэх тул зөвлөлдөхөд, Лю Түншюнь: цэргийн хүч бөлүүхэн бөгөөд морь, тэмээ цөөн. Гагцхүү мянган тэмээ хүнс зөөмүй. Бас цэргийн ардад шийтгэн өгч уяуулах хүнсийг зөөхөд хүрэхгүй. Зүй нь Хамид одоож хүчийг тэгшилж шийтгэвээс нийлмүй.*⁴⁸

Мөн дарь, зэр зэвсэг, хувцас хунар, хүнсний зэрэг зүйл Бархөлд ирэхэд хагас сар болох учир энэ үед цэргийн хүрээнд цугласан 5400 мориноос гадна, Ансигаас дайчилсан 2000 гаруй морь, 1000 гаруй тэмээг харгалзан үзэж 3000 цэрэг томилж, хүн тутам түр хошоод морь олгож, Хүйст гэх газрын ойр суулгахаар шийдвэрлэсэн буй.⁴⁹

tanggū gūsin sunja morin de acabufi juwe minggan ilan tanggū jakunju cooha be tomilafi ilan tanggū baturu cooha de kooli songkoi niyalma tome ilata bahabuhaci tulgiyen gūwa cooha de niyalma tome taka juwete bubume ambasa, hafasa de inu hontoholome ekiyembume bahabume icihiyahabi]. 127-128.

⁴⁶ Мөн дээрх. 128-129.

⁴⁷ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын 12-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 129.

⁴⁸ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын 14-нд улаан бийрээр цохолсон айлтгал. [... bar kul de isinjia. jai inenggigerenambasa be isabumecoohabelherejalinehebešere de lio tung hiyūncoohaihūsunniyerebime morin temenkomso. damuminggantemenjekujuwembi. gelicoohaurse de icihiyeme bure hūwaitaburekunesun be juwete de isirakū. giyanihami de genefihūsun be teksilemeicihiyaciambi]. 136.

⁴⁹ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын шинийн 6-нд улаан бийрээр цохолсон айлтгал.

Чингэж, Манжийн төрөөс 1755 оны 8-9 сарын хооронд цэргийн хүнсэнд хэрэглэх гүү, өртөө, улаанд бэлтгэсэн мориноос гадна, хятад цэргийн морийг татаж, 4000 цэрэгт морь, хүнс залгамжлуулж, Илд давшин орж, Амарсанаагийн бослогыг дарахад бэлэн болов.

4. Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлиг

Дээрх мэт нэг сарын хугацаанд цугласан морины тоог харгалзаж, цэрэг томилж, Зүүнгарт дахин давшихаар бэлтгэж бүхийд, Илээс гарсан Дашдаваагийн харьяат Соном гэгч жанжин Банди, Оёнгу, Саарал нар ойрадуудад цохигдсон талаар 1755 оны 10 сарын шинийн 6-нд;

... Би энэ жил Эрээн хавиргаас Са [Саарал] жанжинг дагалдаж цэрэг оров. Бие өвдөж Дашдаваагийн нутагт одож тэжээлгэсэн бөлгөө. Найман сарын сүүлээр Дашдаваагийн зайсан Нямак олонд хэлсэн газарт, “эдүгээ Илийн жанжин сайдууд цөм хулгайд цохигдож, хорьж сахиулмуй. Бид их эзэн [Тэнгэрийн тэтгэсэн]-ийг гуйж одсугай” хэмээн Дашдаваагийн хатан, зайсан нар гурван мянга гаруй өрхийг авч жич Са жанжины том хүү Гүмүжав, Са жанжины бага хүү [Юлус]-ийн хамтаар Жүлдүс замаар Турфаныг эрж ирэв.⁵⁰

хэмээн мэдүүлэв. Үүнд, жанжин Цэрэн энэхүү Сономын мэдүүлсэн нь хиа Манчугаас сонссон тул Амарсанаагийн тараасан худал үг байж болзошгүй гэж сэжиглэж, бүгдийн дарга Аминдоог Эрээн хавиргын замаар тус мэдээ баттай эсэхийг магадлуулж илгээсэн байна.⁵¹ Ташрамд дурдахад, дээрх айлтгалд нэр гарах Зүүнгарын бага Цэрэндондовын хүү Дашдаваа, түүний ах Манж, Цэрэннамжил, дүү Дэлгэр, Бэгэл болон Манжийн ахмад хүү Нэмэхжаргал, хоёрдугаар хүү Төгсхашиха, түүний хүү Муушар, Төгсхашихайн 3 настай хүү Бүтэх, Цэрэннамжилын ахмад хүү Ишноров, хоёрдугаар хүү Цэвээнбанжуур нар цөм ойрадуудын дотоодын тэмцлийн улмаас амь үрэгдсэн тул Дашдаваагийн

⁵⁰ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын 22-нд улаан бийрээр цохолсон айлтгал. [... bi ere aniya eren habirgan ci sa jiyanggiyün be dahalame cooha dosika. beyenimefidasidawainukte de genefujihebihe. jakünbiyaimanashün de dasidawaijaisangnimakgeren de alaha bade teilijiyanggiyünambasagemuhülha de tabcilabufihorimetuwakiyabuha. muse amba ejen de baimegeneki seme dasidawaisargan, jaisang se, ilanmingganfuncereboigon be gaifi jai sajiyanggiyüniahünijugumjab, sajiyanggiyüniajigejui be suwaliyamejuldusjugünderiturfan be baimejihe]. 202-203.

⁵¹ Чингэхдээ, Тэнгэрийн тэтгэсэн хаанаас Аминдоод ... “*Та Амарсанаагийн дэмий цуурхсан үгэнд айж, нэг учир бүрхэгдсэнээс бус таныг ял хийх газаргүй. Эдүгээ Галсандорж нар бичиг бичиж, тус тусын нутгийн ардад ухуулж захисан бөгөөд зайсан нар Галсандорж зэрэг сайд тайж нар дагалдаагаар даруй манай жанжин сайд нарын хамт их цэргийг авч тогтоож ирмүй*” хэмээн давхар Эрээн хавиргын тайж нарт ухуулахыг зарлиг болгож илгээжээ. *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын шинийн 6-нд улаан бийрээр цохолсон айлтгал.

бэлбэсэн хатан Гончигдулам болон хоёр охин⁵², харьяат 5000 гаруй өрх албатыг Амарсанаа, Саарал нар Илд орсон цагаас харилцан булаалдах болсон билээ.⁵³

Дээрх Ил дэх цэргийн хүрээ ойрадуудад цохигдсон тухай мэдээг Тэнгэрийн тэтгэсэн хаанд дамжуулах зуур, Дондогманжаас Банди, Оёнгу нарыг амжилттай довтолсон тухай Авгас, Үлэмж нарт мэдэгдэхээр илгээсэн буруудын тайж Өлзий-Оршихын хүү Навааныг, Занагаравын харьяат Жаргал барьж өчиг авсан тухай айлтгав. Наваан бээр, Ил дэх манжийн цэргийн хүрээг ойрадууд довтолсон талаар;

... Хорин есөнд зайсан Басан хойш ирж олонд хэлсэн газарт: “Зайсан Кэсим, Дондогманж, Үгт, Төвшин, Баран, лам нар, хотон бүгд цэрэг авч одож Улаан хөтөлд хүрч нийлж, жанжин сайдуудын цэргийг хаав. Ид байлдаж, нэгэнт хүн барсан тул Бан [Банди] жанжин, О [Оёнгу] эрхин сайд бүгд амиа хорлов. Са [Саарал] жанжин хоёр голын нийлсэн газарт бага замаар Дашидаваагийн зуу хүрэх хүнийг авч зугтаж гарав.”⁵⁴

гэж өчсөн буй. Ийнхүү Ил дэх цэргийн хүрээ ойрадуудад цохигдсан нь лавтай болж, Банди, Оёнгу нар амиа хорлож, Саарал цөөн цэргийн хамт зугтаж гарсныг тус үйл явдлаас даруй сар гаруйн дараа Тэнгэрийн тэтгэсэн хаан мэдэв. Мөн Наваан, Дондогманж 20 хүний хамтаар Алтайгаар Амарсанаад мэдээ хүргэхээр одсон, 9 сарын шинийн 8-нд Хадааны отогт хүрэхэд Авгас, Норовринчин нар байлдаж байсан тухай мэдээлжээ.⁵⁵ Тиймээс Тэнгэрийн тэтгэсэн хаанаас жанжин Цэрэнд, Норовринчинтэй нийлмэгц, Авгас, Хадааны нутгийг чадахаар хядаж, олзолсон морь малыг цэргүүдэд хуваан өгч, хүүхэд эмэгтэйчүүдийг Норовринчинд шагнахыг зарлиг болгосон байна.⁵⁶

Үүний дээр, өрнө замын өртөөг залгамжлуулахаар илгээсэн, бүгдийн дарга Аминдоо Банди, Оёнгу нар ойрадуудад цохигдсон тухай айлтгасан айлтгалд;

⁵² *Шинжааны данс*, Боть 12. ТТ20 он (1755)-ы 7 сарын 15-нд Сааралын айлтгасан айлтгал. 131-134. 1756 оны 4 сард Дашдаваагийн хатан Гончигдулам нас барсан тул түүний нэг охиныг хоггойдын Чингүнжавт шагнан өгчээ. *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 26. ТТ21 он (1756)-ы 4 сарын цагаан хулгана өдрийн зурвас.

⁵³ *Шинжааны данс*, Боть 12. ТТ20 он (1755)-ы 7 сарын 15-ны Банди, Саарал, Оёнгу нарын айлтгал. 123-126.

⁵⁴ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын 24-нд улаан бийрээр цохолсон айлтгал. [... orin uyun de jaisang basing amasi jifi geren de alaha bade. jaisang kesim, dondok manji, ukto, tubsin, barang, lamasa, hoise uhei cooha gaimе genefi ulan kutul de isibume amcafi jiyanggiün ambasai cooha be kaha. jing tabcin sindame balai niyalma jafara de ban jiyanggiün, o aliha amban gemu beye beyebe araha. san jiyanggiün juwe birai (hunggis, buksurgan) acan i bade ajige jugün deri dasidawa i tanggū isire niyalma be gaifi ukcamae tucike]. 219-220.

⁵⁵ Мөн тэнд. 220.

⁵⁶ *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 20. ТТ20 он (1755)-ы 10 сарын хөх хулгана өдрийн зурвас.

... Хязгаар дахиныг тогтоогч жанжин сайдууд айлтгаж, Аминдоо намайг түшмэл цэрэг авч Хүйтэн, Хар ус хорьдугаар өртөөнөөс нааш, Улаан усанд хүргэж өртөө суулгахад цахар занги хоёр, цахар, халх цэрэг нэг зуун наян дөрвөн хүн, морь таван зуун жар, тэмээ жаран гурав авч хорин өртөөнд, өртөө дэсэлж тавь хэмээсэн бөлгөө. Эдүгээ байцааваас түшмэл цэргийн дотор хулгайд цохигдож гарч эс чадсанаас гадна, одоо бүхий занги хоёр, цэрэг нэг зуун гучин гурав, морь хорин гурав, тэмээ хорь үлдэв. Хулгайд цохигдсон, жич унасан морь бүгд таван зуун гучин гурав, тэмээ дөчин дөрөв, гарч эс чадсан тавин нэгэн цэрэг залгамжилж хэрэв эрж хүрч ирвээс, жич хүрч ирснийг үзэж өргөн барьж мэдүүлсүгэй.⁵⁷

гэж буй. Иймээс Илд цэрэг давшихад урьдаар өртөө суулгах зайлшгүй шаардлагатай тул, буцаж ирээгүй цэргийг Аминдоод тушааж, дээрх өртөө залгамжлуулахад томилсноос үлдсэн 133 цэргээс 20-ийг үлдээж, үлдсэн 113 цэрэгт олгох морь, тэмээ, хүнсийг хурдан шийтгэж өгөхийг дайчлан захирагч сайд Дөү Биньд тушааж, хэвээр хүрээг дагалдуулж өртөө тавихад бэлтгүүлэхээр болж, хэрэв хүрэлцэхгүй болбаас авч орсон цэргээс нөхөж суулгахаар тогтов.⁵⁸

Харин Ил дэх цэргийн хүрээ ойрадуудад цохигдсон мэдээтэй зэрэгцээд, Зүүнгатр довтлох тэргүүн ангийн цэргийг 1755 оны 9 сарын 28-нд мордуулж, араас нь өртөө суулгах 119 цэрэгт морь, тэмээ шийтгэн өгч, хурдан илгээх жанжин Цэрэнгийн тушаалын дагуу Ниншягийн жанжин Хоки, дайчлан захирагч сайд Дөү Бинь нар өөлд гүн Дамбайн адуулсан 100 гаруй мориноос 81 морь, амуу зөөж хүрч ирсэн тэмээнээс 18 тэмээ тус тус сонгож, өртөө суулгах цахар, халх 35 хүнд өгч мордуулсан байна.⁵⁹ Үүний дээр, Ансийн хамааргасан дайчлан захирагч сайд Е Дашюнаас 1600 морийг 6 анги болгож, 10 сарын шинэдээс дараа дараагаар мордуулсан тухай бичиг хүрч ирсэн

⁵⁷ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын 11-нд улаан бийрээр цохолсон айлтгал. [... amargi be toktobure jiyanggiün ambasa wesimburi amindaο mimbe hafan cooha gaifi kuiten, kara usu orici giyamun ci ebsi, ulan usu de isibume giyamun tebure de cahar janggin juwe, cahar kalka cooha emu tanggū jakūnju duin niyalma, morin sunja tanggū ninju, temen ninju ilan gaifi orin giyamun de giyamun aname sindaha bihe. te baicaci hafan coohai dorgi hūlha de tabcilabufi tucime mutehekūngge ci tulgiyen, ne bisire janggin juwe, cooha emu tanggū gūsin ilan, morin orin ilan, temen orin funche. hūlha de tabcilabuha, jai tuheke morin uheri sunja tanggū gūsin ilan, temen dehi duin, tucime mutehekū susai emu cooha sirame aika baime isinjici jai isinjia be tuwame alibume boolaki shebi]. 126-127.

⁵⁸ Мөн тэнд.

⁵⁹ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын 17-ны Хоки, Дөү Бинь нарын айлтгал. 250-252. Мөн Цэрэн, өмнө орсон түшмэл цэргийн хүнс ачиж хүргэхэд нэмж хэрэгсэх 50-60 тэмээ болон дэд ангийн цэргийг мордуулахад шаардах 800 тэмээ, 2000 морийг хүргэж ирэхийг тушаасан тул Ансигаас татсан 800 тэмээнээс нөхөж олгохоос гадна, өртөөнд суулгах цахар, халх нарт олгох 2898 мориноос гадна, монгол газарчийг томилж илгээх, гэнэтийн шийдвэрлэх яаралтай хэрэгт хэрэгсэх морийг тооцож бүгд 3100 үлэх тул олон газраас дайчилж авч ирэх морийг хурдан ирүүлэхийг тушаав.

авч зам зуур буй тул, урьдаар өртөө суулгах тэргүүн ангид орсон түшмэл цэрэгт нэмж өгөх 1500 гаруй морийг шийтгэн өгч, араас нь дэд ангийн цэргийг мордуулахаар тогтсон боловч⁶⁰, Ил дэх цэргийн хүрээ ойрадуудад цохигдож, Банди, Оёнгү нар амиа хорлож, Саарал цөөн цэргийн хамт зугтаж гарсныг тус үйл явдлаас даруй сар гаруйн дараа Тэнгэрийн тэтгэсэн хаан мэдэв.

Гэвч Тэнгэрийн тэтгэсэн хаанаас өрнө замын цэрэг, умард замын цэргийг хүлээлгүй даруй давшин орохыг зарлиг болгосон⁶¹, мөн 500 цэрэг авч туршуулд одсон бэйл Цэмцүгжав, *Галсандоржийн хүү Норовринчинг Авгас, Хадааны нутагт үгүй* хэмээн мэдээлсэн тул уг чөлөөнд урьдаар дээрх зайсангуудын нутгийг довтолж олзолсон эд зүйл, морь малаар цэргийн хүнс залгамжилж цааш давшихаар болов.

Үүнээс гадна, Юйбоо зайсан Басан, Зэвэг нар эдүгээ Алтайн цаана Цагаан хужирын зэрэг газарт цэрэг орж Амарсанааг бариваас болно⁶² хэмээсэн тул Хадаха, Арантай нарт өрнө замын цэргийг хүлээлгүй даруй цэрэг авч Цагаан хужирын зэрэг газарт хүрээд Амарсанаа тэнд аваас даруй барих, үгүй бол цааш чадахаар давших, эс бөгөөс түр байдалтай газрыг эзэлж, өрнө замд мэдээ хүргэж, хүч хавсарч Амарсанааг барихаар тогтжээ.⁶³

Гэтэл энэ үед Зүүнгараас Дашдаваагийн бэлэвсэн хатан Гончигдулам 1950 гаруй өрхийн 8940 гаруй амыг авч, Илийн лам нарын тушаалыг дагалгүй, зам зуур олон удаа дайсантай байлдсаар гарч ирсэн тул⁶⁴, тэдэнд түр нутаглах газар, идэх хүнс, мал шагнаж өгөх шаардлага тулгарав.⁶⁵ Тиймээс хиа Мачан, аравны

⁶⁰ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын 29-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 252.

⁶¹ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын 14-нд улаан бийрээр цохолсон айлтгал. [... gūnici jalafungga, ioi boo, galzangdorji se inu siran siran i uthai isinambi. ... baicaci amindao de juwe tanggū baturu cooha bufi neneme jurafi julduš jugūn deri jiyanggiyūn sebe okdonobuha. ... sirabume jidere kunesun morin isinjime, amargi cooha be aliyarakū, uthai šuwe dosiki. aika isinafi uthai dosifi icihiyaci acara nashūn bici juwe minggan coohai dorgici emu minggan i morin hūsun be teksilefi neneme unggiki. ... ili be ejeleme toktoburakū oci ojarahū].

⁶² БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив, *Цэргийн тухайн газрын манж айлтгалын эвхмэл*, ТТ20 он (1755)-ы 10 сарын 16-нд улаан бийрээр цохолсон айлтгал. Энд нэр гарах Цагаан хужир гэх газар болбаас Хасагт одох хамгийн дөт зам ажээ.

⁶³ Мөн тэнд.

⁶⁴ Дашдаваагийн хатан Гончигдулам Илээс 3000 гаруй өрх албатын хамт гарсан ба зам зуур 3 удаа дайсантай байлджээ. Үүнд, Түрфанаас нааш ирэхэд их мянганы Баатар, цоохор, хэрээд, урууд отогтой байлдсан бөгөөд шархадсан, дайсанд олзлогдсон, амь үрэгдсэн ард 700 гаруй өрх аж. Үүний дээр зам зуур үлдсэн 300 гаруй өрх хоцорсныг хасч 1500 гаруй өрх албатын хамт 1755 оны 10 сард Бархөлд иржээ. *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 11 сарын 18-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 418.

⁶⁵ Энд дээрх Зүүнгараас дагаж ирсэн Дашдаваагийн харьяат 8000 гаруй ам, Бэгэлийн доорд 1000 гаруй ам нийт 10000 орчим амд, Манжийн төрөөс хүнс залгамжлуулсан нэг жишээ дурдахад, 1756 оны 4 сарын 17-нд сул сайд Бүрин, Очир, Толь нарт амуу 20 таар, буурцаг 80 таар, хуурсан

дарга Амбоог гаргаж, дээрх Сономоор газарчлуулж Дашдаваагийн хатан, зайсан нарт;

*... Эзний зарлигийг дагаж, ид цэрэг авч тэрсэлсэн хулгайг арилгаж одоход таны чин хэмээн их эзнийг гуйж ирснийг сонсож нэгэнтээгүүр айлтгаж, нэгэнтээгүүр хүн зарж таныг харгалзаж угтуулав. Та Бархөлд ирээд сайхан доорд ардыг хурааж, сайн бэлчээр усыг үзэж жарган сууж, эзний хишгийг хүлээж бай.*⁶⁶

хэмээн хэлүүлж, Манжийн төрд хүч өгч зүтгэе хэмээвээс даруй 500-600 цэрэг гаргах зарлиг буулгав. Харин Дашдаваагийн албатаас цэрэгт дайчлах 1000 орчим сайн эрс буй боловч гурван хүн тутамын нэг нь унах унаагүй явган явах тул Хоки даруй Ниншя, Жуанлангийн 400 гаруй цэргийг Бархөлд сэрэмжлэн суулгаад, эдгээр цэргийн оронд Дашдаваагийн албатаас нөхөж илгээхээр шийдвэрлэв.⁶⁷ Дээрх зарлигийн хариуд, Гончигдулам хатан дуртайяа өөрийн харьяатаас 800 сайн эрс гаргахаас гадна, 1020 морь, 1100 гаруй хонь, 2500 үхэр, 700 гаруй тэмээг цэргийн хэрэглэлд зарцуулахыг зөвшөөрсөн тул Манжийн төрөөс түүнийг сайшааж Гончигдуламыг *Сэцэн мэргэн хатан* цол өргөмжилж, магнаг торго 10, мөнгө 500 лан, цай 1000 жин шагнажээ.⁶⁸

Тийнхүү 1755 оны 10 сарын эхээр морь, хүнс шийтгэж хоёр ангийн цэрэг бэлтгэж Зүүнгат илгээхэд бэлэн болсон боловч Ил дэх цэргийн хүрээ ойрадуудад нэгэнт цохигдсон учир Манжийн төрөөс Зүүнгат довтлохыг хойшлуулсан буй. Үүнд, өрнө замын цэргийг Тэнгэрийн тэтгэсэн хаанд бараалхсан Галсандорж, Ням зэрэг ойрадын тайж нарыг Бархөлд очмогц, тэдэнтэй хүч нийлж, Эрээн хавиргын Амарсанаад эс дагасан отгуудаас цэргийн хүчийг зузаатгах, удалгүй цаг хүйтрэх тул их цэрэг цааш давшваас дэмий морины хүч, хүнс сүйтгэх учир Эрчисийн зэрэг газрын өвс, бэлчээр талхлагдсан учраас өртөө тавилгүй, харин

будаа 100 таар, цайны навч 200 боодол тус тус олгож, тэдний харьяат ардад тархаалгаж байжээ. *Шинжааны данс*, Боть 18. ТТ21 он (1756)-ы 5 сарын 22-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 213-214.

⁶⁶ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 10 сарын 22-нд улаан бийрээр цохолсон айлтгал. [... ejen be hese be dahamejingcoohagaifudarkanhülha be geterembumegenere de suwenihing seme baimejihe be donjifi emu deriwesimbume, emu deriniyalmatakūrafisuwembetuwašatameokdobuha. suwe bar kul de isinafaikaifejergiuurse be bargiyatamesainongkomuke be tuwamejirgametemejenikesi be aliyamebaisu. ...]. 206-207.

⁶⁷ *Шинжааны данс*, Боть 13. 209-210.

⁶⁸ *Шинжааны данс*, Боть 14. ТТ20 он (1755)-ы 11 сарын 23-ны Хокийн айлтгал. 137. 417. Энэхүү Дашдаваагийн албатууд цаашид Бархөл, Алтай, Орхоноор дамжин Халуунголд хүрсэн буюу 1755-1759 он хүртэлх үйл явдлын талаар, Оюунжаргал О. *Манж Чин улсаас Монголчуудыг захирсан бодлого (Ойрадуудын жишээн дээр)*. Улаанбаатар. 2009. 99-123 дэлгэрэнгүй өгүүлсэн буй.

Буянт, Алтайн ойр Хайрт, Солби, Улаагчины зэрэг чухал газарт бэлэн тавьсан өртөөгөөр өрнө замын мэдээг авч умар замын цэргийг тус газарт морь малыг тэжээж өвөлжүүлэхээр тогтов.⁶⁹ Үүнд, харуулын ойр хавсаргаж татсан өртөөний цэрэг, мориноос дайчилж тасарсан өртөөг залгамжлахыг халхын гүн Дамиранд тушааж, бэйл Цэдэнжавыг Улиастайд үлдээж өртөөг захируулж, солон, халх, цахарын цэрэгт 3 сарын хүнс, гүү, үхэр, хонийг олгов.⁷⁰

5. Амарсанааг барих төлөвлөгөө

1755 оны 10 сард Манжийн төрөөс Илд давших хоёр замын цэргийг зогсоосон авч, Даваач, Галсандорж зэрэг нэр нөлөө бүхий хүмүүсээр Амарсанааг барьж өгөхийг ухуулсан албан бичиг бичүүлж Зүүнгат илгээх, *хулгайн хүчийг хуваах* буюу хойд, хошуудын тайж нарын гэр бүлийг барьцаанд авах зэрэг арга хэмжээ авч эхлэв. Тухайлбал, Тэнгэрийн тэтгэсэн хаан Ил дэх цэргийн хүрээ ойрадуудад цохигдсон авч, хуувийн сайд Саарал уруудын зайсан Начиншашихагийн хүү Шигширгэд баригдсаныг мэдээд, Шигширгэд, “Сонсвоос, Ёст нар Сааралыг чиний нутагт бүхийг мэдээд, хэд хэдэн удаа чамаас авах гэхэд, чи огт эс илгээв. ... Чи үнэхээр миний хишгийг сүслэн зүтгэж, Амарсанааг барих, эсбөгөөс хулгайд туслан явсан Ёст, Дондогманж, Кэсим нарыг барьж чадваас, би эрхгүй хүнд хишиг хүртээмүй” хэмээн элч илгээхийн сацуу⁷¹, давхар ойрадуудад “одоо таны Амарсанаад дагалдан явсан ялыг уучилж хэлтрүүлсэн. Хэрэв Амарсанааг барьж хүргэж ирвээс их эзэн [Тэнгэрийн тэтгэсэн хаан] хэтэрхий хишиг хүртээнэ” хэмээх, Амарсанааг барьж өгөхийг ятгасан тод үсгийн ухуулах бичгийг Даваач, Галсандорж гэх мэт хүмүүсээр бичүүлж, Зүүнгат илгээсэн байна.⁷²

Үүнээс гадна, 1755 оны 11 сард Тэнгэрийн тэтгэсэн хаан, Даваачаас Амарсанааг хэрхэн барих талаар асуулгасанд;

... Тэнд бүхий дөрвөдийн тайж Бэш-Агаш, хөвүүн ноёдын тайж Норовын зэрэг хэдэн хүн буй. Эд басхүү хэргийг бүтээвээс болмуй. Огт Амарсанаагийн нам эс явав. Би хэвийн учир лавтай мэдэх буюу. Миний санаанд эдэнд захиж, хүчлэн Амарсанааг бариулж цаазыг илэрхийлсүгэй хэмээмүй. Ийн аваас улсын цаазыг илэрхийлвээс болмуй. Хүний сэтгэл мөн амармуй. Гуйх нь, эзэн

⁶⁹ *Шинжааны данс*, Боть 13. ТТ20 он (1755)-ы 11 сарын шинийн 5-нд улаан бийрээр цохолсон айлтгал.

⁷⁰ БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив, *Цэргийн тухайн газрын манж айлтгалын эвхмэл*, ТТ20 он (1755)-ы 10 сарын 16-нд улаан бийрээр цохолсон айлтгал.

⁷¹ *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 22. ТТ20 он (1755)-ы 12 сарын хөх луу өдрийн зурвас.

⁷² *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 17. ТТ20 он (1755)-ы 10 сарын цагаагчин гахай өдрийн зурвас.

*Норов нарт мөн зарлиг буулгах ажааму. Эд эрхгүй сүслэн санаж, зүтгэн явмуй.*⁷³

хэмээсэн тул Бэш-Агаш, Норов нарт элч илгээхийн сацуу, Амарсанаа Үй Зангийн газарт очиж болзошгүй тул тэндэхийн хэрэг шийтгэх мэйрэний занги Сарашан, Шүдай нарт тушааж, Үй Зангийн харуулыг чангатгахын зэрэгцээ, Далай ламд элч илгээж, Амарсанааг барих талаар асуулгасанд;

*...Амарсанаа гэгч эзэнд гуйж дагасан хүн. Түүнийг ван өргөмжилсөн бөгөөд бас өчнөөн хүнд хишиг хүртээв. Эдүгээ Зүүнгарын газрыг бүрэн тогтоож цэрэг татахад лам нарын хатгах үгийг сонсож эзний хүнд хишигийг үтээрхэж дахин урваж оргосныг үзвээс машид мунхаг тэрслүү, огт буян ялгахгүй.*⁷⁴

хэмээн, нэр нөлөө бүхий сайн чадалтай ламыг Зүүнгарт илгээж, Илийн лам нарт Амарсанааг барихыг тушаах тул гагц хулгай баригдах нь цаг хугацааны асуудал хэмээв.

Энд тэмдэглэхэд, Ил дэх цэргийн хүрээг ойрадуудын цуг хотон нар довтолсон мэдээ буй тул, хоёр замын цэрэг Зүүнгарт давшихад, Амарсанаа хотонд зугтаж болзошгүй хэмээн 1755 оны 11 сард Нагачад цэрэг өгч Аксуд тосгуулж суулгажээ.⁷⁵

Үүний дээр, Тэнгэрийн тэтгэсэн хаан 1755 оны 12 сард Амарсанаагийн зааврын дагуу бослого гаргасан зайсангуудын гэр бүлийг барьцаанд авах зарлиг буулгав. Үүнд, 1755 оны 9 сарын 11-нд Хөвхөрийн газраас солон, халх цэргийг авч Ил дэх мэдээг авуулахаар илгээсэн хөх отго Монголдой, 48 дугаар өртөөнөөс зугтаж гарсан халх Даваа, өөлд Баян нар, *Хойдын тайж нар гэр бүлээ санаж, цөм*

⁷³ *Зүүнгарын бодлогын бичиг*, ЖЗ. Дэвтэр 21. ТТ20 он (1755)-ы 11 сарын цагаан луу өдрийн зурвас. [... tubade bisire durbet i taiji beši agasi, kubun noyat i taiji norbu i jergi udu niyalma bi. ese kemuni baita be mutebuci ombi. umai amursana i ici yaburakū. mini an i ucuri tengkime sarangge. mini gūnin de ese de jasifi hūsutuleme amursana be jafabufi fafun i tuwancihiyaki sembi. uttu ohode kurun i fafun be iletuleci ombime, niyalmai mujilen inu selambi. bairengge; ejen norbu sede inu hese wasimbureo. ese urunakū hukšeme gūnime faššame yabumbi].

⁷⁴ БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив, *Цэргийн тухайн газрын манж айлтгалын эвхмэл*, ТТ20 он (1755)-ы 12 сарын 25-нд улаан бийрээр цохолсон айлтгал. [amursana serengge ejen de baime dahaha niyalma. imbe wang fungneche bime geli utala ujen kesi isibuha. te jun gar i babe yooni toktobufi cooha gocire de lamasai šusihyere gisun be donjifi ejen i ujen kesi be urgedefi dasame ubašafi ukaka be tuwaci umesi hūlhi fudasihūn. cohome hūhuri eterakū].

⁷⁵ *Шинжааны данс*, Боть 14. ТТ20 он (1755)-ы 12 сарын 16-нд улаан бийрээр цохолсон айлтгал. 190-192. Дээрх айлтгалд гарах, Амарсанааг хотонд зугтаж очихоос сэргийлж Аксуд илгээсэн Нагача 1756 онд өвдөж нас барсан тул Тэнгэрийн тэтгэсэн хаан бэйс Нагачагийн дүү Дагвад түүний хэргэмийг залгамжлуулж, Халхад суулгасан Чимхүүрийн хүү жүн ван Цэвдэндоржийн зэрэг засаг нарын хамт нэг газарт нутаглуулахаар болжээ. *Шинжааны данс*. Боть 18. 178-180. Гэвч удалгүй дээрх Нагачагийн хэргэмийг залгамжилсан түүний дүү Дагва өвдөж үгүй болсон тул Тэнгэрийн тэтгэсэн хаан Нагачагийн эх Даш, түүний дүү Балж, Үлэмж нартай зөвлөлдөж, Балжид Нагачагийн хэргэмийг залгамжлуулахаар болж, Нагача, Дагва нар цэрэгт сайтар зүтгэж явсан хэмээн Тамирын хүнс цалингийн цэснээс 100 лан мөнгө авч тэдний ар гэрт өгөхөөр болов. *Шинжааны данс*. Боть 18. 239-240.

Амарсанааг гаслан занамуй хэмээн мэдүүлсэний дагуу, Тэнгэрийн тэтгэсэн хаан халх нарт хуваан шагнасан Амарсанаагийн зайсан Мэнд, Чойжавын зэрэг 18 зайсангийн гэр бүлийг байцаан гаргаж, Бээжинд ирүүлэх буулгав.⁷⁶ Үүнд, Тэнгэрийн тэтгэсэн хаанаас Амарсанааг дагаж бослого гаргасан зайсангуудын гэр бүлийн дотор зайсан Амаржаргал, Убаш, Батжаргал нарын гэр бүл буй эсэхийг тодруулахыг тушаасанд, Хадаха, Цэвдэнжав нар Амарсанаагийн албатыг халх нарт хуваан шагнасан данстай тулган үзэхэд⁷⁷, Амарсанаагийн зайсан Амаржаргал, Мэклэч, Убаш, Батжаргал, Зан, Дэрбэшил, Удашан, Намжил, Сэвдэн, Хотой нарын гэр бүл 1754 онд Манжид дагаж ирэхэд цөм дайнд амь үрэгдсэн, мөн Амаржаргал нарыг барих урьд амь үрэгдсэн зайсан Зальт, оргосон зайсан Басангийн гэр бүлийг нэгэнт Бээжинд хүргүүлсэн тул, Сэцэн хан аймагт шагнасан Амаржаргалын цуг барьсан зайсан Жоч, Хотон, Эвгэлэн, Дондог нарын гэр бүлийн 21 ам, Засагт хан аймагт шагнасан Амарсанааг дагаж оргосон зайсан Гүмүжавын гэр бүлийн 6 ам, мөн Сайн ноён аймагт шагнасан Мөнхийн гэр бүл, Чимхүүрт шагнасан зайсан Мэндийн эхнэр, хүүхэд, оргосон зайсан Шихам, Тогтомүт, Баярт нарын гэр бүлийн 8 ам, нийт 39 амыг тус тус гаргуулж 1756 оны 1 сард багтааж Бээжинд хүргэхээр тогтов.⁷⁸

Хүснэгт 1.

Манжийн төрөөс барьцаанд авсан зайсангуудын гэр бүл, хүн ам

№	Зайсангийн нэрс	Хүн амын тоо	Гэр бүлийн гишүүд	Хэн болох	Бусад
I	II		III		IV
Манжид баригдсан Амарсанаагийн зайсангууд(1-9)					
1	Амаржаргал		Түүний гэр бүл цөм дайнд үрэгдсэн		
2	Мэнд	2	Бяцханхөвүүн Өсөх	Эхнэр Хүү	Жагсаалын дарга Минжүүр Бээжинд хүргэсэн
3	Мөнх	2	Хонгор Яримпил	Эхнэр Хүү	
4	Мэклэч		Түүний гэр бүл цөм дайнд үрэгдсэн		
5	Жоч	6	Убшанз Амар Мухулай, Санчир, Хоно Бойсин	Ээж Эхнэр Хөвгүүд Охин	Сэцэн хан аймгаас хүн гаргаж Бээжинд хүргэсэн
6	Хотон	2	Минж Хичиг	Эхнэр Хүү	

⁷⁶ *Шинжааны данс*, Боть 15. ТТ20 он (1755)-ы 1 сарын шинийн 5-ы Намжил нарын айлтгал. 259-262.

⁷⁷ Мөн гэнд. 260-261.

⁷⁸ Мөн гэнд. 262-263.

7	Эвгэлэн	3	Эрх	Эгч (бэлэвсэн)	Сэцэн хан аймгаас хүн гаргаж Бээжинд хүргэсэн
			Баянөвгөн, Артаг	Охин дүү	
8	Хөшөө	4	Тогтох	Аав	
			Муухай	Эхнэр	
			Басан, Сүнгэ	Хөвгүүд	
			Төмөр	Охин	
9	Дондог	5	Басан	Эхнэр	
			Хуримт, Хурим	Хөвгүүд	
			Элбэг, Мэнджаргал	Охид	
10	Залт (Амаржаргал нарыг барих урьд амь үрэгдсэн)	2	Ням	Эхнэр	
			Гэндэнжав	Нямын аав	
Амарсанааг дагаж оргосон зайсангуудын гэр бүл (11-23)					
11	Убаш		Түүний гэр бүл цөм дайнд үрэгдсэн		
12	Гүмүжав	6	Хархираа	Ээж	Засагт хан аймгаас хүн гаргаж Бээжинд хүргэсэн
			Жүжмаа	Эхнэр	
			Баянжаргал, Цогоо, Тавдай	Хөвгүүд	
			Чэгэр	Охин	
13	Басан	2	Амар	Эхнэр	1755 онд хуувийн сайд Жаохуй түүний эцэг Хотонгийн цуг Бээжинд хүргэсэн
			Бодай	Охин	
14	Шихам	3	Аяуу	Эхнэр	Жагсаалын дарга Минжүүр Бээжинд хүргэсэн
			Болд, Төмөр	Хөвгүүд	
15	Тогтомүт	4	Томок	Эхнэр	
			Амаржаргал	Хүү	
			Буянт, Бөмбөш	Охид	
16	Баярт	1	Агсагал (түүний ээж дайнд үрэгдсэн)	Хүү	Жагсаалын дарга Минжүүр Бээжинд хүргэсэн
17- 23	Батжаргал, Зан, Дэрбэшил, Убаш, Намж, Сэвдэн, Хотой нарын гэр бүл бүгд дайнд амь үрэгдсэн				

Тийнхүү Манжийн төрөөс Засагт хан, Сэцэн хан, Сайн ноён аймгуудад хуваан шагнасан, Амарсанаа болон түүнийг дагаж бослого гаргасан зайсангуудын гэр

бүлийг Бээжинд барьцаанд авч, Амарсанааг барин өгч, “өөрийн гэр бүлээр сольж, ял зольж болох болзол” тавих болов.⁷⁹

Нэгэн зүйл тэмдэглэхэд, энэ удаа Илд цэрэг давшихад, замд таарсан ойрадуудыг хэрхэх тухай Тэнгэрийн тэтгэсэн хаан 1755 оны 11 сард жанжин, сайд нарт;

*... Энэ удаа цэрэг ороход урьд удаа цэрэг орсонд огт адилтгаваас үл болмуй. Учирсан хулгай, сэжиглэлтэй ардыг тэдний морь малыг авч хүч нэмбээс болохыг дуртай довтолтугай. Хядаж алваас зохихыг чадах чинээгээр сүрийг бадруулж хядтугай. Өчүүхэн бүү эргэлз.*⁸⁰

хэмээн, Зүүнгат хоёр замын цэрэг ормогц сэжиг бүхий болгоныг устгахыг зөвшөөрч, тэдний морь малаар цэргийн хүнс залгамжлуулах зарлиг буулгав.

Дүгнэлт

Амарсанаагийн зааврын дагуу 1755 оны 8 сард ойрадууд бослого гаргаж, өрнө замын өртөө, Ил дэх Манжийн цэргийн хүрээг амжилттай довтолсон авч, манжийн жанжин сайдууд Өрөнгөөс баригдсан ойрадуудаас авсан мэдээллийн дагуу, халх дахь хойд, хошууд нарыг хурааж, тэднийг угтахаар Алтайг давсан буучин отгийг устгав.

Харин Бээжинд суух Тэнгэрийн тэтгэсэн хаан, Зүүнгат болж буй үйл явдлыг цаг тухайд нь мэдээгүйн дээр, өрнө замын өртөө тасарснаар Банди, Оёнгү, Саарал нартай холбоогүй болсон тул эхний ээлжинд 7000 цэрэг цуглуулж, Илд үлдээсэн халх, сахар 500 цэрэгтэй хүч хавсарч бослогыг дарахаар төлөвлөж байсан боловч бодит байдал дээр цэрэг цуглуулахаас илүү тэдний унах морь, идэх хүнсийг шийдвэрлэхэд цаг хугацаа шаардлагатай байв.

Улмаар хоёр замын цэрэг цуглуулж, морь, хүнс бэлтгэж, өвлийн хүйтнээс урьтаж Амарсанаагийн бослогыг дарахаар бэлтгэх явцад, 1755 оны 10 сарын

⁷⁹ Халхад бүхий Амарсанаагийн албатуудаас гадна, 1754 онд Амарсанаа, Нэмэх нар Манжид дагаж ирэхэд зам зуур урианхай нарт булаагдсан хойд, хошууд нарыг байцаан гаргаж, мөн адил халх дөрвөн аймагт хуваан шагнаж байжээ. Жишээ дурдахад, 1755 оны 12 сарын 22-нд Арантай, халхын бэйл Норовжав урианхай нараас байцааж гаргасан Амарсанаа, Нэмэх нарын харьяат 75 амыг Улиастайд хүргэж ирүүлсэн тул халх дөрвөн аймагт хуваан шагнах тухай Тэнгэрийн тэтгэсэн хаанд айлтгасан байна. *Шинжааны данс*, Боть 14. 378-379.

⁸⁰ *Шинжааны данс*, Боть 15. ТТ20 он (1755)-ы 11 сарын шинийн 6-нд улаан бийрээр цохолсон айлтгал. [... ere mudan сооha dosire de onggolo mudan сооha dosika de fuhali duibuleci ogorakū. usaraha hūlha kenehunjecuke urse be ceni morin ulha be gaifi hūsun nonggici ojongge be cinghai tabcilakini. gisabume waci acarangge be mutere ebsihe horon be badarambume gisabukini. heni ume niyenyehunjere].

эхээр Дашдаваагийн албатууд Бархөлд ирж, 1755 оны 8 сард Ил дэх Манжийн цэргийн хүрээ ойрадуудад цохигдож Банди, Оёнгу нар амиа хорлосон болохыг мэдэгдсэнээр сая Зүүнгарт цэрэг давшихыг хойшлуулж, Далай ламаас сайн чадалтай лам томилон Илд илгээж, лам нараас Зүүнгарын мэдээг авах, Даваачийн саналын дагуу ойрадуудын дунд нэр нөлөө бүхий тайж нарт элч илгээхийн сацуу, халхад боол болгосон хойд, хошуудын зайсангуудын гэр бүлийг барьцаанд авчээ.

Тийнхүү Амарсанаагийн тооцоолсончлон Чингийн төрөөс богино хугацаанд цэрэг гаргаж, морь хүнс залгамжилж ирж эс чадсан боловч Амарсанаа болон Амаржаргал, Мэнд зэрэг 23 зайсангийн гэр бүл Манжид баригдсаныг мэдсэн зайсан Шигширгэ, Түвшин нар олзонд байсан хуувийн сайд Сааралыг сулласан явдал нь 1755 оны 12 сард босогчид хоорондоо байлдах нөхцөл болсон билээ. Өөрөөр хэлбэл, Манжийн төрөөс 1755 оны 8 сараас тус оны 12 сар хүртэл хэрэгжүүлсэн бодлого үйл ажиллагааны дотроос босогчдын гэр бүлийг барьцаанд авсан явдал нь тус бослого амжилт эс олоход гол нөлөө үзүүлсэн байна.

Abstract

On the rebellion of Amarsana is one of the most interesting incidents which took place during Manchu era in Mongolian history. There are many different sagas and legends circulating in our *durvud* and *uriankhai* ethnics groups from Altai Mountains, which defines Amarsana as last hero in history who fought against Manchurians for independence of Oirat people. Some historians also share this theory and sees him as patriot and a hero.

The very first facts about Amarsana can be found in ZasagGonchig paper from 25th September 1750, reserved in Mongolian National Central Archive. From these archived materials, we can see that his actions and memory of him as mentioned above conflict with each other. On the rebellion of Amarsana against Qing Dynasty has certainly has shaped his position in history. My master's thesis was based on facts and materials reserved in Mongolian National Central Archive, and addresses the historical environment and conditions which led to On the rebellion of Amarsana, it's aftermath against Qing Dynasty.

Ном зүй

1. Алтанзаяа, Л. “Монголчуудын Манжийн эсрэг 1755-1758 оны тэмцэл ба Живзундамба хутагтын шавь нар”, *Монголчуудын Манжийн эсрэг 1755-1758 оны тэмцэл*, Улаанбаатар, 2007, 84-92.
2. Баярцэцэг, Н. “Амарсанаагийн бослогын тухай орос сурвалжийн мэдээ”, *1755-1758 оны Манжийн эсрэг Монголчуудын зэвсэгт тэмцлийн түүхийн асуудал*, Улаанбаатар, 2019, 40-65.

3. Бенжамин Леви/ Б.Нацагдорж (орч). “Зүүнгар дахь Чингийн аян дайн ба сарнисан ойрадуудыг Ирид нутаглуулсан нь”, *Historia Mongolarum*, v. X. Улаанбаатар, 2011.
4. Бадамхаган, С. (эрх.) *Монгол улсын угсаатны зүй(Ойрадын угсаатны зүй)*. Боть 2. Улаанбаатар, 1996.
5. Буянчуулган, Б. *Дөрвөн Өөлдийн түүх*. Б.Түвшинтөгс, Д.Баярсайхан (хөр). // *Bibliotheca Oiratica*. Том.Х. Улаанбаатар, 2008.
6. Буянчуулган, Б. *Өөлд олноор тэмцсэн бүлэг*. Д.Баярсайхан (хөр). // *Bibliotheca Oiratica*. Том.ХХIV. Улаанбаатар, 2012.
7. Гантулга, Ц. *Алтайн Урианхайчууд*. Улаанбаатар, 2000.
8. Гэрэлбадрах, Ж. *Монголын нутаг дэвсгэр, хил хязгаарын түүх*. Улаанбаатар, 2006.
9. Далай, Ч. *Ойрад Монголын түүх*. Улаанбаатар, 2006.
10. Дашням, Г нар. *Баруун Монголын хан, хэргэмтэн, засаг, тайж, түшмэд, ямба олсон лам, суусан газар орныг байцаасан цэс оршив*. Улаанбаатар, 2003.
11. Доржира, Ё. *Ойрад түүхийн дурсгалууд*. Шинжаан, 1992.
12. Жамбалдорж, Ц. “Манж Чин улсын үеийн ойрад ноёдын хөргийн тухайд”, *Ойрад Монголын түүх, соёлын асуудлууд*, v. VI, Улаанбаатар, 2014: 32-43.
13. Жамбалдорж, Ц. “Амарсанаа, Даваач нарын зөрчлийн шалтгаан”, *Ойрад Монголын түүх, соёлын асуудлууд*, v. X, Улаанбаатар, 2017: 110-123.
14. Жамбалдорж, Ц. “Амарсанаагийн бослогын эхлэл: Сурвалж ба судалгаа”, *1755-1758 оны Манжийн эсрэг Монголчуудын зэвсэгт тэмцлийн түүхийн асуудал*, Улаанбаатар, 2019: 66-120.
15. Ишжамц, Н. *Монголын ард түмний 1755-1758 оны тусгаар тогтнолын зэвсэгт тэмцэл(Амарсанаа, Чингүнжав нарын бослого)*. Улаанбаатар, 1962.
16. Мөнхөө, До. *Баруун хязгаарын эртний монгол газрын нэрийн товч тольт (Хятад сурвалж бичгийн жишээн дээр)*. Боть 1, 2. Шинжаан, 2013.
17. Намсрай. *Дөрвөн Ойрадын түүх*. Хөх хот, 1993.
18. Намсрай. *Дайчин улсын үеийн Монголын түүх*. Хөх хот, 1993.
19. Нацагдорж, Ш. *Манжийн эрхшээлд байсан үеийн халхын хураангуй түүх (1691-1911)*. Улаанбаатар, 1963.
20. Нацагдорж, Ш. *Монголын феодализмын үндсэн замнал (Түүхэн найруулал)*. Улаанбаатар, 1978.
21. Одонхөлөг. *Монгол үндэстний орчин үеийн цуут хүмүүс*. Хөх хот, 1990.
22. Очир, А. *Монголын ойрадуудын түүхийн товч*. Улаанбаатар, 1993.
23. Очир, А., Дисан, Т. *Монгол улсын өөлдүүд*. Улаанбаатар, 1999.
24. Ока Хироки. “Цэнгүнжав ба Санзайдорж”, *Сайн ноён хан аймгийн Сэцэн чин вангийн хошууны түүх, соёлын судалгаа*. Улаанбаатар, 2018, 228-230.
25. Оюунжаргал, О. *Манж Чин улсаас Монголчуудыг захирсан бодлого (Ойрадуудын жишээн дээр)*. Улаанбаатар, 2009.
26. Оюунжаргал, О. “Чингүнжавын бослогын өмнөх харуулд холбогдох дансны тухай”, *Монголын түүх судлал ба сурвалж*, Улаанбаатар, 2009, 92-119.

27. Оюунжаргал, О. “Чингүнжавын бослого ба Халхын нутгийг тэлэх асуудал”, *1755-1758 оны Манжийн эсрэг Монголчуудын зэвсэгт тэмцлийн түүхийн асуудал*, Улаанбаатар, 2019, 28-40.
28. Саруул, И., Шүрхүү, Д. *Академич Н.Ишжамцын бүтээл туурвил*. Боть 1, 2. Улаанбаатар, 2011.
29. Содбилэг, Т. *Түүхийн гар дэвтэр*. Боть 2. Хөх хот, 1989.
30. Сүхбаатар, На. (эмх.) *Ойрад монголын түүхэнд холбогдох сурвалж бичгүүд*. Боть 1-3. Улаанбаатар, 2001, 2002.
31. Сүхбаатар, На. *Монголын түүхийн тод үсгийн сурвалжууд*. // *Bibliotheca Oiratica*. Tom.I. Улаанбаатар, 2006.
32. Сүхбаатар, На. “Тод бичгээрх түүхэн сурвалж зохиолуудад 1755-1758 оны хэрэг явдлуудыг тэмдэглэсэн нь”, *Монголчуудын Манжийн эсрэг 1755-1758 оны тэмцэл*, Улаанбаатар, 2007: 28-33.
33. Сүхбаатар, На., Баярсайхан, Д. *Хойдын түүх*. // *Bibliotheca Oiratica*. Tom.LVIII. Улаанбаатар, 2016.
34. Цэрэндорж, Ц. “Тагна урианхайн засаг захиргааны зохион байгуулалтын асуудалд /XVIII-XX зууны эхэн үе/”, *Түүхийн судлал* (№33), Улаанбаатар, 2002. 100-105.
35. Цэрэндорж, Ц. (хөр.) *Өөлдийн ноёдын уг эх түүх*. // *Bibliotheca Oiratica*. Tom.XIV. Улаанбаатар, 2010.
36. Чулуун, С., Жигмэддорж, Э. (эмх.) *XVII-XX зууны эхэн үеийн монголын түүхийн судалгаа*. Улаанбаатар, 2010.